

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Арилжааны хэлцлийг хүчингүй  
болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.6, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2007 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 3060 дугаар арилжааны "Таван толгой" ХК-ийн 116 ширхэг хувьцааг худалдсан 58 дугаар хэлцлийг хүчингүй болгосугай.

2. "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь харилцагчийн 27-855099 тоот дансанд 58 дугаар хэлцлээр арилжаалагдсан "Таван толгой" ХК-ийн 116 ширхэг хувьцааг буцаан бүртгэж, иргэн Ш.Хөхцэцэгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг сэргээх, 27-855099 тоот дансанд байгаа 3,994,460 төгрөгийг иргэн М.Гөлгөөгийн 27-14847 тоот дансанд буцаан байршуулахыг "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. "Таван толгой" ХК-ийн 116 ширхэг хувьцааг худалдан авсантай холбоотойгоор иргэн М.Гөлгөөд хохирол учирсан тохиолдолд барагдуулах арга хэмжээ авахыг Брокер дилерийн "Аргай бэст" ХХК /Д.Ариунболд/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ